

**САЛБАР ХУРАЛДААН-4**  
**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН**  
**БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖИЛТ”**  
**САЛБАР ХУРАЛДААНААС ГАРСАН ЗӨВЛӨМЖ**

**Модератор: Б.Буянтогтох, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга**

---

**Хэлэлцүүлсэн илтгэл:**

- 1. Хувь хүний хөгжлийн сургалт**
- 2. Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн бодлогын арга хэмжээ, хэрэгжилт**
- 3. Эм, зүйн албаны чиг хандлага, сайн туршлага**

**НЭГ. ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:**

1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Тусгай зөвшөөрлийн тухай хууль, ТБОНӨХӨАҮХАТХуулинд гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн зохицуулалттай холбоотой нэмэлт өөрчлөлт оруулах /нөөц бүрдүүлэх, дахин хуваарилах, үнийн өсөлт, эрсдлийн сан, хувийн хэвшил оролцоо, /
2. \ Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон нутгийн нэгжийн статусыг тодорхой болгох, Эрүүл мэндийн газрын бүтцэд эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог бий болгож ажиллуулах;
3. Сумын түвшинд эм зүйн тусламж, үйлчилгээг сайжруулах, сумын эрүүл мэндийн төвд эм зүйч, эм найруулагчийг орон тоогоор ажиллуулах;
4. Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт, хяналтын үйл ажиллагааг цахимжуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх;
5. Холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд үнэлгээ хийж, давхардал, зөрүүг арилгах
6. Өндөр өртөгтэй нарийн ажиллагаатай тоног төхөөрөмжийг даатгалд хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх
7. Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийн байгууллагуудын стандартыг шинэчлэх, шинээр боловсруулах;
8. Хөрөнгө оруулалт, хандив, тусламжаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нэгдсэн зохицуулалтыг хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бүрдүүлэх;

**ХОЁР. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

1. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөц (эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж)-ийн нэгдсэн төлөвлөлтийг тайван цагт боловсронгуй болгох, эрсдэлийн сан үүсгэх
2. Эрүүл мэндийн байгууллагад эм зүйч, эм найруулагч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч нарыг орон тоогоор ажиллуулах;
3. Зардал, үр ашгийн судалгаанд үндэслэн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сонгох, хэрэгцээг урьдчилан тооцоолж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн тасралтгүй байдлыг хангах, хэрэгцээнд үндэслэн хуваарилах
4. Нөөц бүрдүүлж ажиллах хариуцлагыг өндөржүүлэх, үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээтэй уялдуулах,
5. Ерөнхий гэрээний худалдан авалтаар авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлэх, хэрэгцээг тодорхойлохдоо өвчлөлтийн байдал, суурь судалгаанд үндэслэх, эмнэлзүйн удирдамжийг шинэчлэх
6. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт, түгээлтийн дэд бүтцийг аймгийн түвшинд бий болгож, алслагдсан сумдын иргэдийн эмийн хангамж, хүртээмжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;
7. Мэдээллийн урсгалыг сайжруулах, шинэ эм, эмнэлгийн хэрэгслийн мэдээллийг мэдээллийг шуурхай түгээх
8. Төрийн худалдан авах ажиллагааны цахим санг сайжруулах (гэрээг цахим гарын үсгээр шууд баталгаажуулах, эмийн захиалга, шалгараагүй шалтгаан харагдах гэх мэт )
9. Эм, биобэлдмэл, оношлуурыг шинжлэх лабораторийн чадавхи, чанарын хяналтыг сайжруулах, аюулгүй байдлын тандалт судалгааг эрчимжүүлэх, олон улсын стандарт, баримт бичгийг нутагшуулах;
10. Иргэдийн эрүүл мэндийн боловсрол, эмийн зохистой хэрэглээний сургалтад хамруулах, иргэн, эмч, эмийн мэргэжилтний мэдлэг хандлагыг сайжруулах
11. Эмийн бүртгэлд биоэквивалент үнэлгээг нэвтрүүлэх,
12. Эм, биобэлдмэл, оношлуурыг шинжлэх лабораторийн чадавхи, чанарын хяналтыг сайжруулах, аюулгүй байдлын тандалт судалгааг эрчимжүүлэх, олон улсын стандарт, баримт бичгийг нутагшуулах;
13. Эрүүл мэндийн байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, дотоод хяналтын журамд эм зүйн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тусгаж өгөх;

#### **ГУРАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР :**

1. Зардал, үр ашгийн судалгаанд үндэслэн эм, эмнэлгийн хэрэгслийг сонгох, худалдан авах ажиллагаа, нөөц төлөвлөлтийн чиглэлээр оролцогч талуудыг чадавхжуулах, мэргэшүүлэх;
2. Эмийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтад хамруулах, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникч нарыг төгсөлтийн дараах төрөлжсөн нарийн мэргэжлээр сургаж, лицензжүүлэх;
3. Үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулах тогтолцоог бүрдүүлэх

#### **ДӨРӨВ. ТАНДАЛТ, СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**

1. Шинэ дэвшилтэт техник, технологи бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх;
2. Эрүүл мэндийн байгууллагууд тендерээр худалдан авсан болон тасалдал үүссэн, үүсэх эрсдэлтэй эм, эмнэлгийн хэрэгслийн цахим мэдээний сан үүсгэх, үйл ажиллагааг тогтмолжуулах;
3. Бичил биетний тэсвэржилтийн судалгаанд үндэслэн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх нянгийн эсрэг эмийн сонголтыг хийх, хэрэглээний үнэлгээ гаргаж хэвших;

#### **ТАВ. САНХҮҮЖИЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг нэгтгэн, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, эм, эмнэлгийн хэрэгслийн өртгийг бууруулах замаар төсөвт хэмнэлт бий болгох;
2. Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эм зүйч, эм найруулагчдын цалингийн шатлалыг нэмэгдүүлэх;
3. Эмийн төсөвт бүтээгдэхүүний /эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур гэх мэт/ ангилал бий болгох, эмнэлгийн тоног төхөөрөмжийг төсвийн задаргаанд нэмэлт зүйл анги бий болгох, жил бүрийн төсөвт тогтмол тусгах;
4. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, засвар үйлчилгээ болон шинэ дэвшилтэт техник, технологийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх хөрөнгийн сан үүсгэх;
5. Эмийн чанар, аюулгүй байдлын тандалт судалгааг хийх санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгах, холбогдох сангаас санхүүжүүлэх ажлыг тэргүүлэх чиглэлд оруулах;

#### **ЗУРГАА: ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

1. Орчин үеийн шинэлэг технологи шингэсэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд тасалдал үүсэж байгаа эмийг Монгол улсын эмийн бүртгэлд бүртгүүлж, хангамжийн тасралтгүй байдлыг хангах;
2. Худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг хангаж, хадгалалт, тээвэрлэлтийн горимыг мөрдөн, захиалсан эм, эмнэлгийн хэрэгслийг хугацаанд нь нийлүүлэх;
3. Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн нэгдсэн цахим сүлжээг бий болгох
4. Эмийн зохицуулалтын Олон Улсын сүлжээнд нэгдэх, гадаадын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хамтран ажиллах;
5. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын аймагт ажиллаж байгаа эм биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч нарыг ажлын байраар хангаж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах;
6. Эмийн чанар, аюулгүй байдлын тандалт судалгааны чиглэлээр эрүүл мэндийн байгууллага, их, дээд сургууль, төрийн бус байгууллагууд хамтран ажиллах;

